

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

ИЛТГЭХ ХУУДАС

2025 оны 12 дүгээр сарын 05

Улаанбаатар хот

Дүүргийн хэмжээнд хэрэгжиж буй төсөл хөтөлбөрүүдийн
хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай

Нэг.Танилцуулга:

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам”-ыг үндэслэн 2024-2028 онд хэрэгжүүлэх 10 төсөл хөтөлбөрт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн “Гэр хорооллын 20,000 хүртэлх айл өрхийн ариун цэврийн байгууламжийг сайжруулах төсөл” батлах тухай А/26, “Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах” төслийн 2025 оны хэрэгжилт А/27, “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” төслийн 2025 оны хэрэгжилт А/28, “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих” төслийн 2025 оны хэрэгжилт А/29, “Иргэдийн соёлын боловсролыг дээшлүүлэх” төслийн 2025 оны хэрэгжилт А/30, “Ахмад настны хөгжлийг дэмжих” төслийн 2025 оны хэрэгжилт А/31, “Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих” төслийн 2025 оны хэрэгжилт А/32, “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах” төслийн 2025 оны хэрэгжилт А/33, “Боловсрол” төслийн 2025 оны хэрэгжилт А/34 дүгээр тогтоолоор баталсан “Сонгинохайрхан соёл амралтын хүрээлэн байгуулах төсөл” А/41 тогтоолоор тус тус баталсан 10 төсөл, хөтөлбөрийн 29 зорилго 140 үйл ажиллагааны 138 заалтын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг зохион байгуулж ажилласан.

Монгол улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын “Үнэлгээ хийх” журмын 3.2-т заасныг үндэслэн дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны А/223 дугаар тушаалаар 7 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй үнэлгээний багийг байгуулан ажилласан. Тогтоолын 2 дугаар хавсралтын 3 дугаар заалтад заасны дагуу 9 төслийн гүйцэтгэлийг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 05-ны хооронд үнэлгээ хийх ажлыг зохион байгууллаа.

Багийн гишүүдэд:

Багийн ахлагч: Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

Багийн гишүүд: Дүүргийн Засаг даргын хэвлэлийн төлөөлөгч

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Үүрэг даалгаварын биелэлт, захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх Ахлах мэргэжилтэн

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх мэргэжилтэн

Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Хороодын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх мэргэжилтэн

Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтсийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөвлөлт, хэрэгжилт хариуцсан мэргэжилтэн

Багийн нарийн бичгийн дарга Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Бодлогын баримт бичгийн гүйцэтгэлд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх мэргэжилтэн нар ажиллав.

Хоёр.Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зорилго, хамрах хүрээ:

Хяналт-шинжилгээний зорилго нь төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт нь үр дүнд хүрч байгаа эсэхийг тогтоох, арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тодорхойлох, явцын үнэлгээ хийж, шаардлагатай дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудад мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилго агуулсан болно.

Гурав.Үнэлгээний арга, аргачлал:

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам”-ын 3.7-д заасан аргачлалын дагуу төсөл хөтөлбөрийн болон хэрэгжилтийг үнэлэх үнэлгээний 14 асуумжтай маягт боловсруулан үнэлэж, ерөнхий дүнг дараах томъёогоор тооцож гаргаса.

Хэрэгжсэн заалтын тоо

$$\text{Хууль тогтоомж тогтоол} = \frac{\text{Хэрэгжсэн заалтын тоо}}{\text{Нийт заалтын тоо} - \text{Хугацаа болоогүй заалтын тоо}} \times 100\%$$

хийдвэрийн хэрэгжилтийн дүн

Дөрөв.Үнэлгээний олдвор:

Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан төслийн тогтоол, 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, жилийн эцсийн биелэлтийг уншиж танилцан, шаардлагатай нотлох баримтуудыг нэмэлтээр авч үзсэн.

№	Төслийн нэр	Нотломж				
		Захирамж, тушаал	Илтгэх хуудас	Тайлан, судалгаа	Төсвийн зарцуулалт ын тайлан	Бусад
1	“Гэр хорооллын 20,000 хүртэлх айл өрхийн ариун цэврийн байргууламжыг сайжруулах төсөл”		1	3		
2	“Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих хамгаалах төсөл”			3		
3	“Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх төсөл”	2	3	-	1	
4	“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих төсөл”		3	2		
5	“Иргэдийн Соёлын боловсролыг дээшлүүлэх төсөл-2”		2	3		

6	"Ахмад настны хөгжлийг дэмжих төсөл"	8	-	2	-	
7	"Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих төсөл"	2	8	1	1	
8	"Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах төсөл"	-	2	3	-	
9	"Боловсрол төсөл"	-	15	5	1	
НИЙТ		12	34	22	3	

Тав.Үнэлгээний дүгнэлт:

Дүүргийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичигт тулгуурлан дүүргийн Засаг даргын бүрэн эрхийн хугацаанд хэрэгжүүлэх 9 төсөл хөтөлбөрийг гүйцэтгэлээр дүгнэж 1 төсөл хөтөлбөр хэрэгжиж эхлээгүй байна.

№	Төслийн нэр	Зорилтын тоо	Хэрэгжүүлэх үйл ажиллагааны тоо	Заалтын тоо	Төсөл хэрэгжүүлсэн байгууллагын дүн	ХШҮ дүн
				2025		
1	"Гэр хорооллын 20,000 хүртэлх айл өрхийн ариун цэврийн байргууламжыг сайжруулах төсөл"	2	11	9	94,5	85,5
2	"Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих хамгаалах төсөл"	3	14	14	95	90
3	"Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх төсөл"	3	19	16	85,1	80,6
4	"Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих төсөл"	3	21	19	83,7	90
5	"Иргэдийн Соёлын боловсролыг дээшлүүлэх төсөл-2"	3	14	14	93,7	85
6	"Ахмад настны хөгжлийг дэмжих төсөл"	3	18	18	96,1	80,1
7	"Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих төсөл"	4	12	6	88,3	86,2
8	"Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах төсөл"	3	15	15	93,5	92
9	"Боловсрол төсөл"	4	22	15	89,2	87
10	"Сонгинохайрхан соёл амралтын хүрээлэн байгуулах төсөл"	1	4	Хэрэгжээгүй		
Нийт		29	140	138	92	86,2

1. “Гэр хорооллын 20000 айлын нүхэн жорлонг сайжруулах”

Сонгинохайрхан дүүргийн гэр хорооллын 20,000 хүртэлх айл өрхөд MNS 5924:2015 стандартад нийцсэн соруулдаг ариун цэврийн байгууламжийг суурилуулж, бохир усыг соруулж, төв цэвэрлэх байгууламжид нийлүүлэх замаар хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/26 дугаар тогтоолоор тухайн төсөл батлагдаж, дүүргийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн өдөр 2 зорилт 11 арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

“Гэр хорооллын 10,000 айл өрхийн ариун нүхэн жорлонг сайжруулах төсөл” нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны А/26 дугаар тогтоолоор батлагдаж 2 зорилтийн хүрээнд 2022 онд 14, 2023 онд 10, 2024 онд 11 үйл ажиллагааг тус тус хэрэгжүүлсэн байна. Хэрэгжилтийн хувьд 2022 онд 94,5, 2023 онд 85, 2024 онд 91 хувийн хэрэгжилттэй, зарцуулсан санхүүгийн хувьд 2022 онд 6,0 тэрбум, 2023 онд 10,6 тэрбум, 2024 онд 10,9 тэрбум, нийт 26,5 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

“Сонгинохайрхан дүүргийн гэр хорооллын 20,000 хүртэлх айл өрхийн ариун цэврийн байгууламжийг сайжруулах төсөл”-ийн хувьд гүйцэтгэлээр 94,5 хувийн хэрэгжилттэй ч Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3 дугаар заалтад заасан үнэлгээний багийн үнэлгээгээр 86 хувийн гүйцэтгэлтэй үнэлүүллээ. Үнэлгээний багийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/223 дугаар тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, ажлын даалгавар боловсруулан, үнэлэх үйл ажиллагааг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 05-ны хооронд зохион байгууллаа.

Үнэлгээг 4 үндсэн үзүүлэлтийн 14 шалгуур үзүүлэлтээр 100 хүртэл онооны үнэлгээгээр үнэлж, хэрэгжилтийг тооцон ажилласан.

Төлөвлөгөөний 7 заалт (1.1, 1.2)-ын хувьд зорилтот түвшинд хүрээгүй, нотлох баримт хангалтгүй, (1.6)-ын хувьд 2024 болон 2025 оны өргөдөл гомдлын нэгдсэн тайлангаас шүүж тулгалт хийхэд суурь түвшин болон зорилтот түвшин төлөвлөсөн тоон утга зөрүүтэй байсан бөгөөд төлөвлөсөн зорилтот түвшинд хүрээгүй учир бууруулсан. (1.7)-ын хувьд гэрээ байгуулсан өрхийн тоо зөрүүтэй, (2.2)-ын хувьд үг үсэг, утга найруулгын алдаатай, (2.3)-ын хувьд шалгуур үзүүлэлт оновчгүй, зорилтот түвшинд хүрээгүй, уулзалтаас гарсан үр дүн, шийдэл тодорхойгүй, (2.4)-ийн хувьд арга хэмжээг зөв төлөвлөөгүй, шалгуур үзүүлэлт оновчгүй, зөв бичих дүрмийн алдаатай учир үнэлгээ бууруулсан. Хяналт-шинжилгээ үнэлгээний хувь 86% байна.

2. “Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих хамгаалах төсөл” Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих, урьдчилан сэргийлэх, хамт олонд тулгуурласан сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх, архи болон мансууруулах бодис түүний хэрэглээнээс урьдчилан сэргийлэх, тэр дундаа өсвөр насныхан, залуучуудад чиглэсэн сэтгэл зүйн тусламж үйлчилгээг өргөжүүлэх, амиа хорлолтыг бууруулах зорилгоор дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 27 дугаар тогтоолоор “Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах төсөл” батлагдаж, 3 зорилт, 14 арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

“Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах төсөл” нь 2025 оноос анх удаа хэрэгжихээр батлагдаж тухайн жилд 190.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн.

“Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах төсөл”-ийн хувьд гүйцэтгэлээр 95,8 хувийн хэрэгжилттэй ч Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3 дугаар заалтад заасан үнэлгээний багийн үнэлгээгээр 86 хувийн гүйцэтгэлтэй үнэлүүлээ. Үнэлгээний багийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/223 дугаар тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, ажлын даалгавар боловсруулан, үнэлэх үйл ажиллагааг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 05-ны хооронд зохион байгууллаа.

Үнэлгээг 4 үндсэн үзүүлэлтийн 14 шалгуур үзүүлэлтээр 100 хүртэл онооны үнэлгээгээр үнэлж, хэрэгжилтийг тооцон ажилласан.

Тухайн төслийн хувьд 7 заалт (1.1, 1.2, 1.4, 1.5, 1.7, 2.1, 2.2)-ыг зорилтот түвшиндээ хүрсэн, 4 заалт (1.7, 2.1, 2.2, 3.2)-ыг зорилтот түвшингээс бууруулж, 2 заалт (3.1, 3.2)-ыг зорилтот түвшинд хүрээгүй ч тодорхой ажил, арга хэмжээг зохион байгуулсан гэж үзсэн.

Төлөвлөгөөний 5 заалт (1.3, 1.6, 2.3, 2.4, 3.3)-ын хэрэгжилт нь Монгол Улсын Сангийн яамнаас 9 дүгээр сараас хойш санхүүгийн эрхийн хязгаарлалт хийснээс хэрэгжээгүй тул үнэлэх боломжгүй байна.

Бууруулсан заалтуудын шалтгаан:

1.7 – Төлөвлөгөөндөө Их, дээд, ерөнхий боловсролын сургуулиудад сэтгэл зүйн кабенит байгуулна гэсэн боловч Ерөнхий боловсролын сургуулиудад л байгуулсан. Их дээд сургуулиудад байгуулаагүй. 2 төрийн бус байгууллагатай хамтран ажиллахаар хүрэх түвшингээ тодорхойлсон ч зөвхөн 1 байгууллагатай хамтран ажилласан.

2.1 – Ажлаас халшрах хам шинж, сэтгэцийн эрүүл мэндийн талаарх судалгааг дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй 50 ба түүнээс дээш ажилтантай байгууллагуудад хийх, үр дүнтэй аргуудыг тодорхойлох гэсэн заалтын хүрээнд 2000 албан хаагчийг хамруулна гэж тодорхойлсон түвшиндээ хүрээгүй.

2.2 – Хамт олны сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах арга хэмжээг хэрэгжүүлэхдээ зөвхөн эрүүл мэндийн байгууллагыг хамруулсан нь зорилгодоо хүрэх шалгуур үзүүлэлтийг хангаагүй гэж үнэлгээг бууруулсан.

3.2 – Архи хэтрүүлэн хэрэглэдэг, донтох эмгэгтэй (гудамжинд архи уудаг, орон гэргүй) хүмүүст чиглэсэн тусгай арга хэмжээг нийслэлийн “Нийгмийн хамгааллын тусгай төв”-ийг түшиглэн зохион байгуулах арга хэмжээний хүрээнд 2 удаагийн уулзалт зохион байгуулж, 2026 онд төсөл хэрэгжүүлэхээр боловсруулсан гэж тайлагнасан. Мөн шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ өгөхөд зорилтот түвшинд хүрээгүй байна.

Төслийг хэрэгжүүлэх гарааны жилийн бодит гарсан үр дүнг, урьдчилан гаргасан тооцоо судалгаа, бусад шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэхэд

“ХАНГАЛТТАЙ” хэрэгжиж эхэлсэн байна гэсэн үнэлгээ өгч байна. Хяналт-шинжилгээ үнэлгээний хувь 86% байна.

3. **“Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх төсөл”** Дүүргийн хэмжээнд хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрийг төлөвлөхдөө өмнөх оны туршлага, ирэх жилүүдэд хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлагыг тооцоолол судалгааны үндсэн дээр боловсруулж халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх. Тайлант оны хугацаанд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны сургалт, сурталчилгаа, зохион байгуулж байгаа арга хэмжээг тодорхой тоо баримттай, хэрэгжүүлсэн хугацаа, зарцуулсан төсвийг тусгах тал дээр дутмаг байна.

ДИТХ-ын 2021 оны “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх төсөл” батлах тухай А/37 тогтоолоор баталсан.

- 2021 онд 5 зорилт 14 арга хэмжээний хүрээнд төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж 600,3 сая төгрөг зарцуулахаар төсөвлөсөн, гүйцэтгэлийн хувь
- 2022 онд 5 зорилт 15 арга хэмжээний хүрээнд төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж 44,6 сая төгрөг зарцуулахаар төсөвлөсөн, гүйцэтгэлийн хувь 81,66%
- 2023 онд 5 зорилт 19 арга хэмжээний хүрээнд төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж 28,7 сая төгрөг зарцуулахаар төсөвлөсөн, гүйцэтгэлийн хувь 95%
- 2024 онд 5 зорилт 13 арга хэмжээний хүрээнд төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөж 21,5 сая төгрөг зарцуулахаар төсөвлөсөн, гүйцэтгэлийн хувь 92,3% байна. 2021-2024 төслийн хүрээнд нийт 695.1 сая төгрөг зарцуулсан байна.

“Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх төсөл”-ийн хэрэгжилт 80,5 хувийн хэрэгжилттэй байгаа боловч Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3 дугаар заалтад заасан үнэлгээний багийн үнэлгээгээр 95 хувийн гүйцэтгэлтэй үнэллээ.

Үнэлгээг 5 үндсэн үзүүлэлтийн 18 шалгуур үзүүлэлтээр 100 хүртэл онооны үнэлгээгээр үнэлж, хэрэгжилтийг тооцон ажилласан. Өгөгдсөн үнэлгээ:

Зорилтот түвшиндээ хүрсэн 10 заалт (1.1.1, 1.1.3, 1.1.4, 1.2.1, 1.3.2, 2.1.1, 2.1.2, 2.2.2, 3.1.1, 3.1.3) байна.

Хүрсэн түвшин зорилтот түвшинд хүрээгүй, хэрэгжилт хангалтгүй 5 заалт (1.1.2, 1.2.2, 3.2.1, 3.2.2, 3.2.3) байна.

Төлөвлөгөөний 3 заалт (1.3.1, 3.1.2, 3.3.1)-ын хэрэгжилт нь Монгол Улсын Сангийн яамнаас 9 дүгээр сараас хойш санхүүгийн эрхийн хязгаарлалт хийснээс хэрэгжээгүй тул үнэлэх боломжгүй байна.

Бууруулсан заалтуудын шалтгаан:

1.1.2. Төлөвлөсөн арга хэмжээ-Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дархлаажуулалтын нэгжийн тоог үе шаттайгаар нэмэгдүүлэх: гэх арга хэмжээний зорилтот түвшин нь 36 бөгөөд хүрсэн түвшин 6 буюу дархлаажуулалтын цэг 6-аар нэмэгдсэн.

1.2.2. 0-5 насны хүүхэдтэй эцэг, эхчүүдэд болон жирэмсэн эхчүүдэд зориулсан товлотт дархлаажуулалтын талаар сургалтыг сар бүр зохион байгуулах: гэх арга хэмжээний зорилтот түвшин нь 28 удаагийн сургалтыг зохион байгуулна гэсэн бөгөөд биелэлтэд зохион байгуулсан сургалтын тоо тодорхойгүй.

Хэдэн удаагийн сургалтаар хэдэн төрсөн болон жирэмсэн эхийг хамруулсан тухай тусгаагүй.

3.2.1. БЗДХ, ХДХВ -ийн халдвар илрүүлэх сайн дурын шинжилгээ, үйлчилгээг өргөжүүлж, өсвөр үе, залуучуудыг хамруулан, эрт илрүүлэг, эрүүлжилтийг зохион байгуулах: гэх арга хэмжээг 3 шалгуур үзүүлэлтийн хүрээнд хэрэгжүүлэхээр зорьсон. 3 шалгуур үзүүлэлтийн гүйцэтгэлийг бодож дундаж хувийг гаргасан.

3.2.2. ӨЭМТ-үүдтэй хамтран ахлах ангийн сурагчдад /10-12-р анги/ ХДХВ/ДОХ, БЗДХ-аас сэргийлэх сургалт зохион байгуулах: 2 шалгуур үзүүлэлтийн хүрээнд зохион байгуулахаар төлөвлөсөн бөгөөд 2 шалгуур үзүүлэлтийн 1 нь 100% гүйцэтгэлтэй 2 нь 35,9 хувьтай байгаа бөгөөд дундаж нь 67.9%-тай байна.

3.2.3. Дүүргийн нутаг дэвсгэрт байрлах төрийн болон ТББ, хувийн хэвшлийн байгууллага, аж ахуй нэгжийн албан хаагчдад чиглэсэн эрт илрүүлэг, сургалт, арга хэмжээг зохион байгуулах: арга хэмжээний хүрээнд 30 удаагийн арга хэмжээ зохион байгуулна гэж төлөвлөсөн бөгөөд хэрэгжүүлсэн арга хэмжээ хангалтгүй, ТББ, хувийн хэвшлийн ААНБ-д чиглэсэн арга хэмжээ сургалт, эрт илрүүлэг хангалтгүй. Хүрсэн түвшинг буруу бичиж ирүүлсэн.

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний шалгуур үзүүлэлт, зорьж байгаа түвшинг буруу тодорхойлсноос биелэлт хангалтгүй байгаа байдал ажиглагдаж байна. Хяналт-шинжилгээ үнэлгээний хувь 88% байна.

4. **“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих төсөл”** төсөл хөтөлбөр 21 заалтаас 16 заалтыг гүйцэтгэлээр үнэлж, 5 заалт төсвийн тодотголоор төсөв танагдсан тул санхүүжилтийн асуудлаас шалтгаалж хэрэгжээгүй. Эх нярайд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанаржуулах, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх, өвчлөл, эндэгдлийг бууруулах зорилгоор дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/29 дүгээр тогтоолоор “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих төсөл” батлагдаж, дүүргийн Засаг даргын 2025 оны 5 дугаар сарын 19-ны баталсан 3 зорилт, 21 арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

“Эх, хүүхдийн эрүүл мэндийг дэмжих төсөл” нь анх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны А/36 дугаар тогтоолоор батлагдаж, 3 зорилтын хүрээнд 2022 онд 17, 2023 онд 14, 2024 онд 13 үйл ажиллагааг тус тус хэрэгжүүлсэн байна. Хэрэгжилтийн хувьд 2022 онд 98,2, 2023 онд 96,6, 2024 онд 95,3 хувийн хэрэгжилттэй, зарцуулсан санхүүжилтийн хувьд 2021 онд 141,8 сая, 2022 онд 343,6 сая, 2023 онд 29,8 сая, 2024 онд 63,2 сая, нийт 578,4 сая төгрөгийг зарцуулсан байна.

“Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийг дэмжих төсөл”-ийн хувьд гүйцэтгэлээр 83,7 хувийн хэрэгжилттэй ч Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3 дугаар заалтад заасан үнэлгээний багийн үнэлгээгээр 90 хувийн гүйцэтгэлтэй үнэлүүлээ. Үнэлгээний багийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/223 дугаар тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, ажлын даалгавар боловсруулан, үнэлэх үйл ажиллагааг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 05-ны хооронд зохион байгууллаа.

Үнэлгээг 5 үндсэн үзүүлэлтийн 18 шалгуур үзүүлэлтээр 100 хүртэл онооны үнэлгээгээр үнэлж, хэрэгжилтийг тооцон ажилласан.

Тухайн төслийн хувьд 11 заалт (1.1.1, 1.1.3, 1.2.1, 1.2.2, 3.1.1, 3.1.2, 3.1.3, 3.1.4, 3.1.5, 3.3.2, 3.4.1)-ыг зорилтот түвшиндээ хүрсэн, 3 заалт (1.1.2, 1.3.1, 2.2.1)-ыг зорилтот түвшингээс бууруулж, 4 заалт (1.2.3, 2.1.1, 2.1.2, 3.3.1)-ыг зорилтот түвшинд хүрээгүй ч тодорхой ажил, арга хэмжээг зохион байгуулсан тул үнэлгээг нэмэгдүүлж үнэлсэн.

Төлөвлөгөөний 2 заалт (2.3.1, 3.2.1)-ын хэрэгжилт нь Монгол Улсын Сангийн яамнаас 9 дүгээр сараас хойш санхүүгийн эрхийн хязгаарлалт хийсэнээс хэрэгжээгүй тул үнэлэх боломжгүй байна.

Бууруулсан заалтуудын шалтгаан:

1.1.2 —4 арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөсөн ч сургалт, урьдчилан сэргийлэх үзлэг, зөвлөгөө гэсэн 3 арга хэмжээ зохион байгуулсан тул зорилтот түвшиндээ хүрээгүй байна. Мөн шалгуур үзүүлэлтийг төлөвлөгөөнөөс зөрүүтэй тайлагнасан.

1.3.1 —Эрүүл мэндийн байгууллагын эмэгтэйчүүдийн тусламж үйлчилгээний кабинетийн үйл ажиллагааг өргөжүүлж, гэр бүлд чиглэсэн зөвлөгөө мэдээллийн өрөөтэй болох арга хэмжээний шинээр байгуулах өрөөний зорилтот түвшин төлөвлөгөөнд 2 гэж томъёолоод тайланд 1-ээр тусгасан, өөрийн үнэлгээ нь өрөөтэй болоогүй тул хүрсэн түвшинг 0-ээр илэрхийлсэн байна.

2.2.1 —Өсвөр насныханд зориулсан олон нийтийн сүлжээний мэдээлэл, сурталчилгааг боловсруулах, цахим хичээл, зөвлөгөөний сайтыг нээн ажиллуулах хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхдээ төлөвлөгөөндөө 2 шалгуур үзүүлэлт буюу “шинээр үүсгэх цахим сайт тоо”, “шинээр боловсруулах цахим хичээл, тоо” гэж томъёолсон байна. Хэрэгжилтийг гаргахдаа зөвхөн цахим сайтын тоогоор гаргасан тул үнэлгээг бууруулсан.

Төслийг хэрэгжүүлэх гарааны жилийн бодит гарсан үр дүнг, урьдчилан гаргасан тооцоо судалгаа, бусад шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэхэд “ХАНГАЛТТАЙ” хэрэгжиж эхэлсэн байна гэсэн үнэлгээ өгч байна. Хяналт шинжилгээний үнэлгээний хувь 90% байна.

5. “Иргэдийн Соёлын боловсролыг дээшлүүлэх төсөл-2” төсөл хөтөлбөр 14 заалтаас 10 заалтыг гүйцэтгэлээр /6 заалт хугацаа болоогүй, 1 заалт буурсан байна/ үнэлсэн. Иргэдийн соён гэгээрүүлэх, соёл урлагаар дамжуулан хөгжүүлэх, нийгмийн харилцаанд тэгш оролцуулах, соёлын ойлголтуудыг өргөжүүлж, тэднийг эерэг өөрчлөлтөд хүргэх зорилгоор дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/30 дугаар тогтоолоор “Иргэдийн соёлын боловсролыг дээшлүүлэх төсөл-2” батлагдаж, дүүргийн Засаг даргын 2025 оны 5 дугаар сарын 19-ны баталсан 3 зорилт, 14 арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

“Иргэдийн соёлын боловсролыг дээшлүүлэх төсөл” нь дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны А/23 дугаар тогтоолоор батлагдаж, 3 зорилтын хүрээнд 2022 онд 10, 2023 онд 20, 2024 онд 20 үйл ажиллагааг тус тус хэрэгжүүлсэн байна. Хэрэгжилтийн хувьд 2022 онд 99,2, 2023 онд 86,6, 2024 онд 94,4 хувийн хэрэгжилттэй, зарцуулсан санхүүжилтийн хувьд 2021 онд 9,0 сая, 2022 онд 23,4 сая, 2023 онд 25,9 сая, 2024 онд 274,9 сая, нийт 333,3 сая төгрөгийг зарцуулсан байна.

“Иргэдийн соёлын боловсролыг дээшлүүлэх төсөл – 2”-ийн хувьд гүйцэтгэлээр 93,7 хувийн хэрэгжилттэй ч Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43

дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3 дугаар заалтад заасан үнэлгээний багийн үнэлгээгээр 85 хувийн гүйцэтгэлтэй үнэлүүллээ. Үнэлгээний багийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/223 дугаар тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, ажлын даалгавар боловсруулан, үнэлэх үйл ажиллагааг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 05-ны хооронд зохион байгууллаа.

Үнэлгээг 5 үндсэн үзүүлэлтийн 18 шалгуур үзүүлэлтээр 100 хүртэл онооны үнэлгээгээр үнэлж, хэрэгжилтийг тооцон ажилласан.

Тухайн төслийн хувьд 2 үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд нэгдүгээр үе шат буюу 2025 онд төслийг боловсруулах, батлуулахаар томьёолсон тул зорилтот түвшиндээ хүрсэн байна.

Төлөвлөгөөний 5 заалт (4.1.1.1, 4.1.1.2, 4.2.1.1, 4.2.1.2, 4.2.1.3)-ын хэрэгжилт нь Монгол Улсын Сангийн яамнаас 9 дүгээр сараас хойш санхүүгийн эрхийн хязгаарлалт хийсэнээс хэрэгжээгүй тул үнэлэх боломжгүй байна. Төлөвлөгөөний 1 заалт буюу 4.3.1.3 дахь заалтад заагдсан түүх соёлын үл хөдлөх дурсгалын бүртгэл мэдээллийн санд бүртгэлтэй газруудыг газрын мэдээллийн санд бүртгэлжүүлэх ажил нь 2 жилд 1 удаа хийгддэг тул хугацаа болоогүй байна.

Төлөвлөгөөний 1 заалт (4.3.1.1)-ын үнэлгээг зорилтот түвшинд хүрээгүй тул бууруулсан. Хяналт-шинжилгээ үнэлгээний хувь 85% байна.

6. “Ахмад настны хөгжлийг дэмжих төсөл” Ахмад настанд үзүүлэх цогц тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, эрүүл идэвхтэй урт наслалтыг дэмжих, хөдөлмөр эрхлэлт, хөгжил оролцоог дэмжиж ахмад настны талаар нийгэмд эерэг ойлголтыг төлөвшүүлэхэд нутгийн захиргааны, иргэний нийгмийн, нутаг дэвсгэрийн байгууллага, аж ахуйн нэгжийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 31 дүгээр тогтоолоор “Ахмад настны хөгжлийг дэмжих төсөл” батлагдаж, дүүргийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдөр баталсан 3 зорилт 18 арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

“Ахмад настны хөгжлийг дэмжих төсөл” нь анх дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 9/02 дугаар тогтоолоор батлагдаж, 3 зорилтын хүрээнд 2022 онд 17, 2023 онд 23, 2024 онд 21 үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан байна. Хэрэгжилтийн хувьд 2022 онд 97,1, 2023 онд 93,3, 2024 онд 94,5 хувийн хэрэгжилттэй, зарцуулсан санхүүжилтийн хувьд 2022 онд 107,2 сая, 2023 онд 126,5 сая, 2024 онд 217,5 сая нийт 451,2 сая төгрөгийг зарцуулсан байна.

“Ахмад настны хөгжлийг дэмжих төсөл”-ийн хувьд гүйцэтгэлээр 96,1 хувийн хэрэгжилттэй Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3 дугаар заалтад заасан үнэлгээний багийн үнэлгээгээр 90 хувийн гүйцэтгэлтэй үнэлүүллээ. Үнэлгээний багийг дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/223 дугаар тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, ажлын даалгавар боловсруулан, үнэлэх үйл ажиллагааг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 05-ны хооронд зохион байгууллаа.

Үнэлгээг 5 үндсэн үзүүлэлтийн 18 шалгуур үзүүлэлтээр 100 хүртэл онооны үнэлгээгээр үнэлж, хэрэгжилтийг тооцон ажилласан.

Тухайн төслийн хувьд 13 заалт (1.1.1, 1.1.2, 1.2.1, 1.5.1, 2.1.1, 2.2.1, 2.3.1, 3.1.1, 3.2.1, 3.2.2, 3.3.1, 3.4.1, 3.5.1)-ыг зорилтот түвшиндээ хүрсэн 1 заалт (1.4.1)-ыг зорилтот түвшингөөс бууруулж үнэлсэн.

Төлөвлөгөөний 2 заалт (1.5.2, 3.6.1)-ын хэрэгжилт нь Монгол Улсын Сангийн яамнаас 9 дүгээр сараас хойш санхүүгийн эрхийн хязгаарлалт хийснээс хэрэгжээгүй тул үнэлэх боломжгүй байна.

Бууруулсан заалтуудын шалтгаан:

1.4.1 – хяналт тавих гэж төлөвлөсөн ч чиглэл хүргүүлсэн албан бичиг, хуулийн танилцуулга, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулсан. Энэхүү зохион байгуулсан арга хэмжээг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2022 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 9/02 дугаар тогтоолоор батлагдсан төслийн хүрээнд хэрэгжүүлсэн байсан ажил арга хэмжээ байна.

Төслийг хэрэгжүүлэх гарааны жилийн бодит гарсан үр дүнг, урьдчилан гаргасан тооцоо судалгаа, бусад шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэхэд “ХАНГАЛТТАЙ” хэрэгжиж эхэлсэн байна гэсэн үнэлгээ өгч байна. Хяналт-шинжилгээ үнэлгээний хувь 90% байна.

7. **“Хүүхэд, залуучуудын хөгжлийг дэмжих төсөл”** Хүүхэд залуучуудын хөгжих, нийгмийн амьдралд оролцох эрхийг хангах, чадавхжуулах, тэр дундаа өсвөр насныханд чиглэсэн арга хэмжээг үе шаттайгаар зохион байгуулж, “Залуучуудын хөгжлийг үйлчилгээний төв”-ийг байгуулж, залуу гэр бүлийг дэмжих зорилгоор дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/32 дүгээр тогтоолоор “Хүүхэд, Залуучуудын хөгжлийг дэмжих” батлагдаж, дүүргийн Засаг даргын 2025 оны 5 дугаар сарын 19-ны баталсан 3 зорилт, 21 арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Үнэлгээг 5 үндсэн үзүүлэлтийн 18 шалгуур үзүүлэлтээр 100 хүртэл онооны үнэлгээгээр үнэлж, хэрэгжилтийг тооцон ажилласан.

2025 оны санхүүжилт **206,939,500** байна.

Төслийн 12 заалтаас 6 арга хэмжээ (3.1.1, 3.1.2, 3.1.4, 3.2.1, 3.3.1, 3.4.1) төсвийн хэмнэлтэд шилжсэнтэй холбоотой хийгдээгүй. Гүйцэтгэлээр 5 арга хэмжээ (3.1.3, 3.2.2, 3.2.3, 3.2.4, 3.4.2) үнэлсэн. Бууруулж 1 арга хэмжээ (3.3.2) үнэлсэн. Зорилгодоо хүрэх үр дүнгээ хэрэгжүүлэхийн тулд ирэх жилүүдийн төлөвлөгөөнд оновчтой, бодитой ажлуудыг тусгаж ажиллах шаардлагатай гэж дүгнэж байна. Хяналт-шинжилгээ үнэлгээний хувь 86,6% байна.

8. **“Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах төсөл”** төсөл хөтөлбөр 14 заалтаас 10 заалтыг гүйцэтгэлээр үнэлж, 4 төсвийн тодотголоор төсөв танагдсан тул санхүүжилтийн асуудлаас шалтгаалж хэрэгжээгүй. 3 Монгол Улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Нийслэл, дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, бусад холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж ажиллах зорилгоор дүүргийн хэмжээнд төслийг хэрэгжүүлэх хэрэгцээ,

шаардлага, статистик тооцоо судалгааг гарган, төслийг 4 жилийн хугацаанд хэрэгжүүлж тодорхой үр дүнд хүрэхээр дэвшүүлсэн үндсэн зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө зэрэг нь оновчтой байна гэж тодорхойлж байна. Төслийг хэрэгжүүлэх гарааны жилийн бодит гарсан үр дүнг, урьдчилан гаргасан тооцоо судалгаа бусад шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлэхэд “ХАНГАЛТТАЙ” хэрэгжиж эхэлсэн байна гэсэн үнэлгээ өгч байна. Хяналт-шинжилгээ үнэлгээний хувь 85% байна.

9. **“Боловсрол төсөл”** Багш, сургалцагчийн хөгжлийг дэмжих хөгжлийг дэмжин чадавхжуулах, хүүхэд бүрт чанартай боловсролыг тэгш, хүртээмжтэй хүргэн, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн орчин нөхцлийг сайжруулах зорилгоор Дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/29 дүгээр тогтоолоор “Боловсрол төсөл” батлагдаж, дүүргийн Засаг даргын 2025 оны 5 дугаар сарын 19-ны баталсан 4 зорилт, 22 арга хэмжээг 2025 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

№	2021 оны “Боловсрол” төсөл батлах	Он	Зорилт	Үйл ажиллагаа	Үйл ажиллагааний хэрэгжилт хувь	Зарцуулсан санхүүжилт
1	тухай А/22 дугаар тогтоолоор батлагдсан	2021	6	16	85	79,0 сая
2		2022	6	19	85,6	77,3 сая
3		2023	6	27	90	146,0 сая
4		2024	6	23	93,9	107,4 сая
Нийт зарцуулсан төсөв						409,7 сая
1	2025 оны “Боловсрол” төсөл батлах тухай А/34 дүгээр тогтоолоор батлагдсан	2025	4	12	86,6	213,241,000

Үнэлгээг 5 үндсэн үзүүлэлтийн 18 шалгуур үзүүлэлтээр 100 хүртэл онооны үнэлгээгээр үнэлж, хэрэгжилтийг тооцон ажилласан.

Төслийн 22 заалтаас 7 арга хэмжээ (1.5,1.6,1.7,1.8, 2.2, 2.3, 3.6) төсвийн хэмнэлтэд шилжсэнтэй холбоотой хийгдээгүй. Гүйцэтгэлээр 11 арга хэмжээ (1.1, 1.4, 2.1, 2.4, 2.5, 3.1, 3.2, 3.4, 4.1,4.2, 4.3) үнэлсэн. Бууруулж 3 арга хэмжээ (1.2,.1.3, 3.3) үнэлсэн.

Бууруулсан заалтуудын шалтгаан:

1.2,1.3 –арга хэмжээ зорилтод түвшин, хүрэх түвшин биелэлтийн тооноос зөрүүтэй,

3.1- арга хэмжээ ёс зүйн сургалт явагдаагүй байна.

3.3 Сурагчдын дунд хооллох зөв дадал, соёл, тэнцвэртэй хооллолтын ач холбогдлыг таниулсан, хүүхдийн хоолны чанар хүртээмжийг нэмэгдүүлсэн ажил зохион байгуулаагүй. Сурагчдын хоолны чанар хүртээмжтэй байгаа эсэхийг тодорлуулах шаадлагатай. Хяналт-шинжилгээ үнэлгээний хувь 90% байна.

Зургаа.Зөвлөмж

Төслийг хэрэгжүүлэх тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа суурь болон зорилтот түвшний тоон утга, хэрэгжүүлэх хугацаа, шаардлагатай хөрөнгийг бодитой, тооцоолж төлөвлөх;

Төслийг хэрэгжүүлэх эдийн засгийн нөөц, бололцоо хүрэлцээтэй эсэхийг урьдчилан тооцоолох;

Зорилго, зорилтоо хэрэгжүүлэхэд чиглэсэн оновчтой, хэмжигдэхүйц, тодорхой хугацаанд хүрч болохуйц арга хэмжээг төлөвлөх;

Төслийн хэрэгжилтийн үр дүнг гүйцэтгэлээр биш бодит үр дүнгээр тооцож, төсөл хэрэгжүүлж байгаа хэлтэс, алба бодлогыг зангидан хэрэгжүүлж байгаагийн хувьд үндсэн чиг үүргийн нэгжүүдэд үүрэг болгон хариуцуулж ажиллах, үр дүнг тооцуулж тайлагнах;

Шаардлагатай тохиолдолд төслийн онцлогийг харгалзаж, жендерийн эрх тэгш байдал, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг урьдчилан тооцолсон байх;

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулинд заагдсан бодлогын баримт бичгийн төрөл болсон төслийг хэрэгжүүлэхэд бүх талын оролцогч байгууллагуудын оролцоог бүрдүүлж, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг дүүргийн Засаг даргын Тамгын газрын үндсэн чиг үүргийн нэгжүүдэд үүрэг болгон хариуцуулж ажиллах;

Төслийг хэрэгжүүлэх үе шат бүрд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр дүүргийн нутаг дэвсгэрийн төрийн болон төрийн бус байгууллагуудыг татан ороцуулж, хамтран ажиллах ажлыг зохион байгуулах.

Төслийн талаар иргэд, олон нийтэд мэдээлж ажиллахыг төрийн захиргааны анхан шатны нэгж болох хороодтой хамтран зохион байгуулж хэрэгжүүлэх.

Тухайн жилийн төлөвлөгөөний биелэлтийг дүүргийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж, тодорхой шийдвэр гаргаж хэрэгжүүлж ажиллах.

Төслийг хэрэгжүүлэх оны төлөвлөгөөг боловсруулахдаа санхүүгийн эрсдэлийг урьдчилан тооцоолох.

Долоо.Хавсралт

Үнэлгээний багийн гишүүдийн үнэлгээний хуудас хавсаргав.

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД

ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН ДАРГА

ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН ГИШҮҮД



(С.ТУУЛМАА)



(Т.СҮХБААТАР)



(Б.МӨНХЗУЛ)

О. Янжинлхам (О.ЯНЖИНЛХАМ)
Ш.О.Эрдэнэ (Ш.ОЮУН-ЭРДЭНЭ)
Л. Оюундарь (Л.ОЮУНДАРЬ)
Ө.Норовдэмид (Ө.НОРОВДЭМИД)